



ТӨВ АЙМГИЙН БОРНУУР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2014 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитын тайлан

ТАБ-ын Дарга, тэргүүлэх аудитор

Л.Жаргалсайхан

И-мэйл: jargsaihan_tuv@yahoo.com

Утас: 70272582

Факс: 01-272-22582

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Аудитын менежер:

О.Амаржаргал

И-мэйл: amaraa_tuv@yahoo.com

Утас: 70273465

Ахлах аудитор Т.Майцэцэг

Утас: 70273465 99018619

И-мэйл: maits2009@yahoo.com

Аймгийн аудитын газрын хаяг:

Төв аймаг Зуунмод сум 1-р баг

Төрийн байгууллагуудын ордон

Цахим хуудас: www.audit.mn

2015 оны 3 дугаар сар

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
8. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
9. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
10. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
11. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
12. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
13. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
14. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
15. Зөвлөмж
16. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.3, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дүгээр зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Борнуур сумын ЗДТГазрын төсвийн 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд ТӨВ-2015/53/СТА-ТТЗ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Төв аймгийн Борнуур сумын ЗДТГазрын төсвийн 2014 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт/УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Төв аймгийн Борнуур сумын ЗДТГазрын 2014 оны төсвийн санхүүгийн тайлангийн аудитыг 2015 оны 03 дүгээр сарын 25-наас 2015 оны 03 дүгээр сарын 27-ныг хүртэл хийхээр төлөвлөн ТАБ-ын аудитын багийн гишүүн аудитор Т.Майцэцэг хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Төв аймгийн Борнуур сумын ЗДТГазрын 2014 оны төсвийн санхүүгийн тайланг 2015 оны 03 дугаар сарын 24-нд ТАБ-т ирүүлсэн байна.

Төрийн аудитын байгууллага аудитыг 2015 оны 03 дүгээр сарын 25-наас 2015 оны 03 дүгээр сарын 27-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2015 оны 03 дугаар сарын 31-нд Төв аймгийн Борнуур сумын ЗДТГазрын удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Төсвийн захирагч нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд ЗГ-ын 2005 оны 233 дугаар тогтоолоор батлагдсан “Үндсэн хөрөнгөд элэгдэл тооцох тухай” журмыг 2014 оны 297 дугаар тогтоолоор хүчингүй болгосон байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дүгээр зүйлийн 1-д “Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын ажлын алба нь Тамгын газар байх бөгөөд дор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ:” гэж энэ байгууллагын үйл ажиллагааны зорилтыг тус хуулийн 33 дүгээр зүйлд тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хуулийн 6.2.-т “Аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн орлогын нэр төрөл, зарлагын ангилал, санхүүжилтийн зориулалт болон төсөв зохиох, батлах, гүйцэтгэлийг зохион байгуулах, тайлагнах үйл ажиллагааг төсвийн болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1.38-д “төсвийн шууд захирагч” гэж төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн төвлөрүүлэн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг” гэж заасны дагуу Төв аймгийн Борнуур сумын ЗДТГазрын дарга Төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Төсвийн шууд захирагчийн төсвийг сумын ИТХурлаас баталж аймгийн Төрийн сангаас олгож байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, НББ-ийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72.4.4-д комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх гэж заасан хуулийн хэрэгжилт хангалтгүй байна. Төсвийн захирагчийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд,УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Төв аймгийн Борнуур сумын ЗДТГазрын төсвийн 2014 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс Төв аймгийн Борнуур сумын ЗДТГазрын удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын хяналтын болон нарийвчилсан 9 горим, сорилыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад ТШЗ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулаагүй, НББ-ийн бодлогын баримт бичгийн номыг баримтлан бүртгэдэг. Бүртгэлийн asolous програм ашигладаг байна.

Төсвийн шууд захирагчид ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг

хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Төв аймгийн Борнуур сумын ЗДТГазрын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн программаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Тус байгууллагын дотоод хяналтын ажлын хэсэг нь ажлын төлөвлөгөө тайлан ирүүлээгүй, ажиллаагүй. Иймд хөрөнгийн тооллого, өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалт зэрэг санхүүгийн механизмыг бүхэлд нь хянадаггүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, түүнийг хэрэгжүүлэхээр гаргасан заавар, журмыг хэрэгжүүлж, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагааг бүртгэлийн програмаар боловсруулж байна. Эдгээр журам нь УСНББОУС-тай нийцсэн байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

Батлагдсан төсвийг хуваарийн дагуу Төв аймгийн Борнуур сумын ЗДТГазрын Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Борнуур сумын НЕҮ нь 2014 онд Төсөвт зардлын эх үүсвэрийг орон нутгийн татварын орлогоор 50382.0 мянган төгрөг, аймгийн санхүүгийн дэмжлэгээр 256368.1 мянган төгрөг авахаар батлагдсан байна.

ЗДТГ-ын төсвийг оны эхэнд 209665.1 мянган төгрөгөөр, Багийн төсвийг 42021.3 мянган төгрөгөөр тус тус баталсан. 2014.07.18-ний өдрийн иргэдийн Төлөөлөгчдийн 02-р хуралдааны 07 тоот тогтоолоор ЗДТГ-ын урсгал төсвийг 4333.2 мянган төгрөгөөр, 2014.10.29-ний өдрийн 03-р хуралдаанаар 7951.4 мянган төгрөгөөр тодотгосон.

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 2014 онд ЗДТГазар батлагдсан төлөвлөгөөгөөр 209665.1 мянган төгрөг зарцуулахаас 218218.9 мянган төгрөгийг зарцуулж, 8553.8 мянган төгрөгийг хэтрүүлэн зарцуулсан. Энэ нь сумын ИТХ-аас 7951.4 мянган төгрөгийг тодотгосон нь нөлөөлсөн ба төсвийн зарцуулаагүй үлдэгдэл 3730.7 мянган төгрөгийг төсөвт татан төвлөрүүлсэн байна.

ЗДТГазрын нэмэлт санхүүжилтийн харилцах дансаар 34121.0 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж зарцуулаагүй үлдэгдэл 3810.6 мянган төгрөгийг сумын орон нутгийн орлогын дансанд төвлөрүүлж авлага үүсгэсэн.

Баг нь орон нутгийн төсвөөс 42021.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал зардалд 41241.6 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 779.7 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр хяналтын болон нарийвчилсан 10 горим, сорил гүйцэтгэв.

Үр дагаварыг тодорхойлж чадвал: Эдгээр эрсдэлүүд нь төсвийг хэмнэлтгүй зарцуулсан, төсвийг үр ашиггүй зарцуулсан, төсвийн зориулалтыг зөрчсөн, хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг сулруулж цаашид хөрөнгийг үрэгдүүлэх, чанар байдлыг алдагдуулах, байгууллагын үйл ажиллагааны цар хүрээг бууруулсан, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхгүй зөрчдөг зэрэг муу үр дагаварт хүрч болзошгүй байна

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Төв аймгийн Борнуур сумын ЗДТГазрын төсвийн 2014 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад цаг хугацааны хязгаардагдмал байдлаас шалтгаалан үндсэн цалингийн зардлыг дүнгээр тулган шалгасан ба санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний дүнтэй ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний дараах алдаа илэрсэн байна. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн балансын үлдэгдлийг тодруулга тайлан, журнал, тооллогын бүртгэлтэй тулган шалгахад Борнуур сумын Засаг даргын 2014.05.28-ний өдрийн А/265 тоот захирамжаар Засаг даргын орлогч В.Батболдаар ахлуулж 5 хүний бүрэлдхүүнтэйгээр томилсон байна. Тооллогын комисс нь 2014.12.31-ний байдлаар хөрөнгийг тоолж, гарын үсэг зурсан, тооллогын бүртгэлийн дүн байвал зохих хөрөнгийн дүнгээс 3154679.6 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. Энэ нь ТБОНӨТХуулийн 72.4.4-д комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн: Тооллогын комисс нь 3154679.6 мянган төгрөгийн хөрөнгийг зөрүүтэй тоолсон тооллогын комиссын гишүүдэд арга хэмжээ тооцож ирүүлэх албан шаардлага бичсэн.

2. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн 02-р хуралдааны тогтоолоор ЗДТГ-ын урсгал төсвийг 4333.2 мянган төгрөгөөр, 03-р хуралдааны тогтоолоор 7951.4 мянган төгрөгөөр тус тус тодотгосоныг батлагдсан төлөвлөгөөнд өөрчлөлт оруулаагүй байна. Төсвийн тухай хуулийн 34.2.Засаг дарга дараах тохиолдолд тухайн жилийн төсвийн тодотголыг боловсруулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ: 34.2.1.дээд шатны төсөвт тодотгол хийсний улмаас тухайн шатны төсөвт тодотгол хийх зайлшгүй шаардлага бий болсон; 34.2.2.урьдчилан тооцох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, зарлага нэмэгдэж, орон нутгийн төсөв

алдагдалтай болох нөхцөл байдал бий болсон; Мөн хуулийн 66-р зүйл Сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх 66.1.4.иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан орон нутгийн төсвийг түүнийг баталснаас хойш ажлын долоон өдрийн дотор аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлэх гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн: Төсвийн тухай хуулийн 34.2.1, 34.2.2.-д заасан шаардлага хангасан тохиолдолд төсвийн тодотголыг сумын Засаг дарга боловсруулж, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх 66.1.4-д иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан орон нутгийн төсвийг түүнийг баталснаас хойш ажлын долоон өдрийн дотор аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлэх гэж заасныг мөрдөж ажиллах зөвлөмж өгсөн

3. Сумын хөгжлийн стратегийн тухай ном хийлгэхээр ИТХурлаар тодотгол хийлгэж 1000.0 мянган төгрөг шилжүүлсэн боловч номоо аваагүй байна. 1000.0 мянган төгрөгийг тайланд авлагаар тусгаагүй зардал болгосон байна. Санхүүгийн тайлангийн оршин байх, эрх ба үүрэг зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: 1000.0 мянган төгрөгийн номыг орлого авах буюу авлагаар тайлагнаж хариу ирүүлэхээр зөвлөмж өгсөн

4. Бараа материалын 350401, 350402 дансны орлогын 9316.3 мянган төгрөгийн гүйлгээг зөв ангилан бүртгэсэн эсэхийг шалгахад 4539.8 мянган төгрөгийн барилга засварын материалыг буруу ангилан бүртгэсэн нь Сангийн сайдын 2006 оны 388-р тушаалын 4.16 Бараа материалыг ангилж бүртгэхдээ дансны нэгдсэн жагсаалт болон холбогдох УСНББОУС-ыг стандартыг мөрдөнө. Сангийн сайдын 2005 оны 276-р тушаалаар батлагдсан дансны жагсаалт зэргийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Сангийн сайдын 2006 оны 388-р тушаалын 4.16 –д заасны дагуу бараа материалыг үнэн зөв ангилан бүртгэж тайлагнаж зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага бичсэн

5. БМ-ын тодруулгын тайлангаарх тээвэр шатахууны орлого нь мөнгөн гүйлгээний тайлангаарх тээвэр шатахууны зардлаас 4503.2 мянган төгрөгөөр илүү тайлагнагдсан байна. Энэ нь засаг даргын нөөцийн зардал, бусад төсөл хөтөлбөрийн зардлаас шатахууны зардал гаргасантай холбоотой байна. Харин зарлага нь үр дүнгийн тайлангаас 7431.3 мянган төгрөгөөр зөрүүтэй байгаа нь өөр зардалд тайлагнасанатай холбоо. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 4.1.2-д санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэх; Сангийн сайдын 2006 оны 388-р тушаалын 4.16 Бараа материалыг ангилж бүртгэхдээ дансны нэгдсэн жагсаалт болон холбогдох УСНББОУС-ыг стандартыг мөрдөнө гэснийг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн: Шатахууны зардлыг үнэн зөв ангилан бүртгэх ба бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах зөвлөмж өгсөн

6. Албан томилолтоор ажилласан төрийн албан хаагчид нь албан томилолтоор гүйцэтгэсэн ажлынхаа үр дүнг удирдах албан тушаалтандаа хугацаандаа танилцуулдаггүй 30 хоногоос дээш хоногийн дараа томилолтоо дүгнүүлдэг, танилцуулдаг ч удирдлага томилолт хаасан огноо тавьдаггүй нийтлэг зөрчил 2655.5 мянган төгрөг байна. Мөн томилолтийн хуудас баталгаажуулаагүй, хаалгаагүй, байхгүйгээр 358.0 мянган төгрөгийг олгосон зөрчил байна. Засгийн Газрын 1995 оны 218-р тогтоолын 3.12 заалт “Албан томилолтын зардлын тооцоог ирснээсээ хойш ажлын 5 өдөрт багтаан гүйцэтгэсэн ажлынхаа үр дүнг албан томилолт олгосон удирдах албан тушаалтанд танилцуулан томилолтын үнэмлэх дээрээ гарын үсэг зуруулна” гэж заасныг хэрэгжүүлээгүй байна

Шийдвэрлэсэн: Албан томилолтоор ажилласан төрийн албан хаагчид нь албан томилолтоор гүйцэтгэсэн ажлынхаа үр дүнг удирдах албан тушаалтандаа хугацаандаа танилцуулдаггүй танилцуулдаг ч удирдлага томилолт хаасан огноо тавьдаггүй нийтлэг зөрчил 2655.5 мянган төгрөгийг зөрчлийг зогсоох болон албан томилолтийн хуудас баталлуулаагүй, хаалгаагүй томилолт 358.0 мянган төгрөгийг олгосон байгааг төлүүлэх төлбөрийн акт тогтоосон.

Материаллаг бус дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. Байгууллагын НББ-ийн бодлогын баримт бичгийг авчраагүй НББ-ийн бодлогын баримт бичгийн ном ашигладаг байна. НББ-ийн тухай хуулийн 17.2. Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь санхүү, бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан баталж, мөрдөж ажиллана гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн: НББ-ийн бодлогын баримт бичгийг санхүү, бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн шинэчлэн боловсруулж мөрдөх зөвлөмж өгсөн.

2. Бэлэн мөнгөний тайланд зарлагын баримт болон шагнал, тэтгэмж болон бусад зардлын гардуулалт байхгүй. Харилцахаас бараа материалын зардал шилжүүлэхдээ нэхэмжлэл болох анхан шатны баримтгүйгээр 2067.9 мянган төгрөгийг шилжүүлсэн. Гэхдээ БМ-ын дансанд орлого авч зарлагын гүйлгээ хийгдсэн БЗД-ын данснаас 191.0 мянган төгрөгийн шатахууны зардлыг нэхэмжлэлгүй шилжүүлсэн, 144.6 мянган төгрөгийн материалын үнэ анхан шатны баримтгүйгээр шилжсэн. БЗД-ын данснаас 191.0 мянган төгрөгийн шатахууны зардлыг нэхэмжлэлгүй шилжүүлсэн, 144.6 мянган төгрөгийн материалын үнэ анхан шатны баримтын шилжүүлсэн. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 7.6-д Анхан шатны баримтын бүрдэлт, үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна, Сангийн сайдын 2012 оны 276-р тушаалын 1-р хавсралтаар батлагдсан Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмын заалтыг хэрэгжүүлээгүй

Шийдвэрлэсэн: 2739.1 мянган төгрөгийн зөрчлийг таслан зогсоох анхан шатны баримтын бүрдэл, тайлан гаргалтыг сайжруулах зөвлөмж өгсөн.

3. Мөнгөн гүйлгээний тайлангийн орлогын дүнг журналын дүнтэй тулган шалгахад ЗДТГазрын харилцах дансанд 9309.0 мянган төгрөгийн Нэмэлт санхүүжилтийн дансны 5060.5 мянган төгрөг нь буцаж орсон орлогын гүйлгээг мөнгөн хөрөнгийн журналд тусгаагүй. Энэ нь Засгийн газрын 2012 оны 205-р тогтоол ТСанийн үйл ажиллагааны журам 7.11-д Тухайн байгууллагын данснаас дараах тохиолдолд орлого бууруулах гүйлгээ хийхийг зөвшөөрнө 7.11.3, 7.11.4 –д заасан заалтыг зөрчсөн байна

Шийдвэрлэсэн: 14369.5 мянган төгрөгийн зөрчлийг таслан зогсоох, орлого бууруулах бичилтийг мөнгөн хөрөнгийн журналд бүрэн тусгаж байх зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитын явцад алдаа залруулаагүй болно.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Тухайн аудитын хамрах хүрээний асуудал боловч аудитын хугацааны шалтгаанаас аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй хөрөнгийн тооллогыг ажиглах, үндсэн хөрөнгөөс түүвэрлэн хяналтын тооллого хийх ба цалингийн тооцооллыг давтан шалгах асуудлыг завсрын аудитаар нөхөн шалгахаар тогтоов.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Төв аймгийн Борнуур сумын ЗДТГазрын төсвийн 2014 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 3192333.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба үүнээс 358.0 мянган төгрөгийн төлбөрийн акт, 3159219.4 мянган төгрөгийн албан шаардлага, 32755.7 мянган төгрөгийн зөрчлийг таслан зогсоох өвлөмж өгөв.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Төв аймгийн Борнуур сумын ЗДТГазрын төсвийн 2013 оны санхүүгийн тайланд Төв аймгийн Аудитын газраас 6 зөвлөмж өгсөнөөс Хөрөнгийн тооллогыг цаг хугацаанд нь чанартай хийж тооцоо бодсон актаар баталгаажуулж байх ба тайлан гаргалт, тооцоо бодолтыг сайжруулах, Тусгай зориулалттай сангуудын зарцуулалт, тайлагналт хяналт тавих зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт:

Хязгаарлалттай санал дүгнэлт

Дээрх алдаа, зөрчлийг эс тооцвол Төв аймгийн Борнуур сумын ЗДТГазрын төсвийн 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил

гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 10 хуудас, байгууллагын санал .. хуудсыг тус тус хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л.ЖАРГАЛСАЙХАН

АУДИТЫН МЕНЕЖЕР

О.АМАРЖАРГАЛ

БЭЛТГЭСЭН: АУДИТОР

Т.МАЙЦЭЦЭГ